ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.04.19 № 433

танай 2022.04.10-ны № 3/4 -т

ДОРНОД АЙМГИЙН БАЯНТҮМЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНТҮМЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА Ж.ЦОГТБААТАР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Баянтүмэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Баянтүмэн сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Баянтүмэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Баянтүмэн сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Баянтүмэн сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.
Хувийг: */Аймгийн/* Сонгуулийн хороонд

Хавсралт 2. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020265

2117144066
ХТҮ4037 9030891

## БАЯНТҮМЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Баянтүмэн сумын Монгол Ардын намын хорооны 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг нийт 32 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлж байна. Үүнд:

1. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг хянадаг болно.
2. Чойбалсан хотоос Баянтүмэн сум хүртэл цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх
3. Засаг даргын Тамгын газрын барилга шинээр барих
4. Сумын төвд 1 км асфальтан хучилттай замыг үргэлжлүүлэн барих
5. Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шат дараалалтай шинэчилнэ
6. Төрийн албан хаагч, багш ажилчдын нийгмийн баталгааг дэмжих
7. Сумын төвийн гудамж талбайг камержуулах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ
8. Хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчинг бүрдүүлж хяналтыг сайжруулна.
9. Сумын төвийн хорооллуудын гудамжны гадна гэрэлтүүлэг үе шаттайгаар гэрэлтүүлэх
10. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг бодлогоор дэмжих
11. Хүн эмнэлгийг /ЭХО аппараттай болгох/
12. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх бодлогыг дэмжиж ажиллах
13. Ахмад настан хүүхдийг эмчлүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хүн эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй хүүхдийг сувилан эрүүлжүүлэх сувилал байгуулна.
14. Эрүүл шүд эрүүл хүүхэд хөтөлбөрийн дэмжин ажиллах.
15. Сургууль спорт заал шинээр барих
16. Сургуулийн дотуур байрны их засвар
17. Сургалтын орчныг сайжруулах зорилгоор сургуулийн дотор их засвар
18. Соёл урлагийн салбарыг дэмжих, өв соёл, сумын дэд хөтөлбөрийг дэмжин ажиллах

19. Орон нутгийн судлах танхимыг тохижуулах, өргөжүүлэх
20. Орон нутгийн номын сангийн уламжлалт үйлчилгээг чанаржуулах, номын баяжилт хийх
21. Бүх багуудад ундны усны худаг гаргах, малчдын санал хүсэлт иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худгуудыг гаргах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.
22. Малжуулах төсөл хэрэгжүүлэх / Хөдөөгийн багийн малчид/
23. Хөдөө аж ахуйн хоршоо, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх, эдийн засаг эрх зүйн нэн таатай орчныг бүрдүүлэх
24. "Органик" хөдөө аж ахуйг хөгжүүлэх төмс хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх, сумын төвийн өрхүүдийг бодлогоор дэмжих, хүлэмж аж ахуй байгуулах
25. Тахианы аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх
26. Өвсний нөөцийн агуулахыг бүх багт байгуулна
27. Малын үүлдэв угсааг сайжруулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих
28. Мал эрүүлжүүлэх мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах
29. Арьс шир боловсруулах цех боловсруулах
30. Сүү боловсруулах цех байгуулах
31. "Жижиг дунд үйлдвэрийг орон нутгийн онцлогт тохируулан, иргэдэд тэгш хүртээх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх"
32. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орлогыг тогтвортой нэмэгдүүлж, жижиг дунд бизнесийг өрх, гэр бүлд нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

БАЯНТҮМЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.04.19 № 434

танай 2022.04.07-ны № 01 -т

ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХӨЛӨНБУЙР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА Ю.ЦЭПЭЛМАА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Хөлөнбуйр сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хөлөнбуйр сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.
Хувийг: */Аймгийн/* Сонгуулийн хороонд

Хавсралт 7. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020258

## ХӨЛӨНБУЙР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 – 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөлөнбуйр сумын Монгол Ардын намын хорооны 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг 4 бодлогын 16-н бүлгийн хүрээнд нийт 52 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлж байна. Үүнд:

2117144066
ХТҮ4037 9030891

### НЭГ: ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1.1. Нутгийн удирдлагын хүрээнд:
1.2. Гадаад харилцааны чиглэлийн хүрээнд:
1.3. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:
1.4. Хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:
1.5. Батлан хамгаалах салбарын хүрээнд:
1.6. Гамшгаас хамгаалах бодлогын хүрээнд:

### ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Эрүүл мэндийн салбарын хүрээнд:
2.2. Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын хүрээнд:
2.3 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд:
2.4. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгох ажлын хүрээнд:

### ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлэх.
3.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх.
3.3. Жижиг дунд үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
3.4. Сумын төвийн газрын ус, дулаан хангамж, хүн амын тохитой , хоггүй цэвэр, эмх цэгцтэй, ногоон байгууламжтай орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
3.5.Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж төсвийн байгууллагын албан хаагч болон иргэд төсвөө хянах, төсвийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилтыг хангана.

### ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1 Байгаль орчныг хамгаалах, унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хомсдлоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй бодлого хэрэгжүүлнэ.

## НЭГ: ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэнээ дээдэлсэн нутгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, төрийн албаны чадавх, хариуцлага, хяналтын тогтолцоог сайжруулж, гадаад харилцааны үр нөлөө хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

2117144066
ХТҮ4037 9030891

### 1.1. Нутгийн удирдлагын хүрээнд:

1.1.1. Иргэдийн санал хүсэлт, зөвлөмжийг сонсож, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нээлттэй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор иргэд хүлээн авах төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, "Иргэдтэй уулзах өдөр", "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулна.
1.1.2. Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх зорилгоор төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрээр иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хүргэж төрийн үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
1.1.3. Суманд хэрэгцээт шаардлагатай мэргэжилтэн, ажилчдыг бэлтгэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
1.1.4. Төрийн байгууллагуудын ажил, үйлчилгээ, албан хаагчдын ажлын байрны чиг үүргийг ил тод болгон үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд тулгуурлан үнэлж, ёс зүй –хариуцлагын тогтолцоог сайжруулна.

### 1.2. Гадаад харилцааны чиглэлийн хүрээнд:

1.2.1. БНХАУ-ын ӨМӨЗО-ы ШБЗХ-тай харилцан хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, харилцан айлчлал хийж аялал жуулчлал, урлаг спорт, соёлын хамтын ажиллагааг үргэлжлүүлж, шинэ гарцыг судалж гадаад харилцаагаа өргөжүүлж ажиллана.

### 1.3. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:

1.3.1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдийн сэтгэл ханамжийг судлан, үр дүнг тооцож ажиллана
1.3.2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд хөндлөнгийн мониторинг хийж үйл ажиллагааг нь сайжруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллана.
1.3.3. Төсвийн сахилга батыг сайжруулахад анхаарч төсвийн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулна.

### 1.4. Хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

1.4.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн албан болон албан бус сургалтыг иргэд олон нийт болон төрийн албан хаагчдад үе шаттайгаар зохион байгуулна.

1.4.2. Сумын дундын Цагдаагийн тасагтай болсонтой холбогдуулан цагдаагийн кубоны өргөтгөлийн барилга барих, алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.3. Захиргааны байгууллагын шийдвэр боловсруулах ажиллагаа болон шийдвэрлэсний дараах хэрэгжилтийг зохион байгуулах ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангаж ажиллана.

1.4.4. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Архигүй амьдрал" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зорилтот бүлгийн иргэдийг архины сайн дурын болон албадан эмчилгээнд үе шаттайгаар хамруулна.

1.4.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам ахиулах ажилд иргэд байгууллагын оролцоог нэмэгдүүлж гэмт хэргийн гаралтыг бууруулах ажлыг удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангаж дэмжлэг үзүүлж ажиллана.

1.4.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, урамшуулалтай малчдын бүлэг холбоод байгуулах шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллана.

1.4.7. Архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн архивын хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна.

1.4.8. Хүний эрхийн Үндэсний Комисс болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран иргэд, олон нийтэд хууль сурталчлан тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар хүний эрхийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангаж ажиллана.

### 1.5. Батлан хамгаалах салбарын хүрээнд:

1.5.1. Батлан хамгаалах салбарын бодлого, зорилт, шийдвэрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулан сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

### 1.6. Гамшгаас хамгаалах бодлогын хүрээнд:

1.6.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд шаардагдах гал унтраах болон аврах ажиллагааны техник багаж хэрэгслийн бааз бүрдүүлэх, гамшгийн эрсдэлийн сан байгуулан ажиллана.

## ХОЁР: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

### 2.1. Эрүүл мэндийн салбарын хүрээнд:

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагыг төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг сайжруулж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлнэ.

2.1.1. Эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх

2.1.2. Хүүхэд, ахмад настны эрүүл мэндийн сувилал, асаргааг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.1.3. Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөж иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

**2.2. Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын хүрээнд:**

Боловсрол, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж хүүхэд, багш болон боловсрол, соёлын ажилтан нэг бүрийн хөгжлийг дэмжинэ.

2.2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдэд уламжлалт зан заншил, өв соёл, түүхээрээ бахархдаг, эх оронч сэтгэлгээ, үнэт зүйлтэй болгон төлөвшүүлэх тэдний хөгжлийг дэмжсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх.

2.2.2. Боловсрол, соёл урлагийн байгууллагын бүх шатны боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлэх, тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлах, мэргэжлийн чиглэлээр бүс, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.2.5. Цэцэрлэг, сургуулийн бүсэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, сургуулийн хүүхдийн хүнсний агуулах, 100 хүүхдийн дотуур байр, хичээлийн А, Б байрны хүзүүвч, хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.2.6. Албан бус насан туршийн боловсролын төвийг тохижуулах, өсвөр үе, залуучуудын ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж төлөвшил, иргэний боловсрол, амьдрах ухааны чадварыг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаанд бодлогоор дэмжин ажиллана.

2.2.7. Сумын соёл урлагийн байгууллагын халаалтын систем шинээр тавих, барилга байгууламжийн их засварыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.2.9. “Түнх” сурын харвааг сурталчлан, хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.

**2.3 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэх, нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжоор хангах ажлын хүрээнд:**

2.3.1. Залуучуудыг олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломж бүрдүүлэх зорилгоор залуучуудын дунд спорт, урлагийн бага наадмыг уламжлал болгон зохион байгуулах, шилдэг залуу гэр бүлийг тодруулах үйл ажиллагааг хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулна.

2.3.2. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж санаачлагч, зөвлөн туслагч, баялаг бүтээгч болгох "Ахмадаа ачлах" хөтөлбөр болон "Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр"-ийг үр дүнтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй эрхлэлтийн болон хувиараа хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад хамруулж, ажлын байраар хангахад анхаарч ажиллана.

2.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчилгээ сувилгаанд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.3.5. Нийтийн биеийн тамирыг дэмжиж өсвөр үе, хүүхэд, залуучууд, ахмад, настанд зориулж хороолол бүрд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спортын цогц талбайтай болгох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

**2.4. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгох ажлын хүрээнд:**

2.4.1. Орлого багатай болон хувиараа аж ахуй, бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг ажлын байр, түрээсийн хөнгөлөлт болон орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд давуу эрхтэйгээр нийлүүлэх, бодлогоор дэмжинэ.

## ГУРАВ: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

**Тогтвортой эдийн засагтай, тэргүүлэх хөгжилтэй сум болно.**

**3.1. Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх, шинэ технологи нэвтрүүлэх.**

3.1.1. Малын тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримталж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхтай малын тоог нэмэгдүүлнэ.

3.1.2. Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлнэ.

3.1.3. Хадлангийн талбайг зөв зохистой ашиглах "Бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг"-ийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар хадлан бэлтгэлийг, нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангана.

3.1.4. Хоршоо, фермерүүдийн үйл ажиллагааг дэмжиж, түүхий эд бэлтгэн нийлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах оновчтой сүлжээг бий болгоход хөдөө аж ахуйн бирж, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

**3.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх.**

3.2.1. Газрын нөөц, боломжид тулгуурлан сумын атар болон атаршсан талбайг сэргээн тариалалт хийж, үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Газар тариалангийн баримтлах бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.

**3.3. Жижиг дунд үйлдвэрлэл, шинэ технологи, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.**

3.3.1. Суманд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

3.3.2. Сумын хөгжлийн сангийн зээлийг нээлттэй төсөл сонгон шалгаруулах замаар олгож, ажлын байр бий болгож нийгмийн даатгалын шимтгэлийг баталгаажуулна.

**3.4. Сумын төвийн газрын ус, дулаан хангамж, хүн амын тохитой, хоггүй цэвэр, эмх цэгцтэй. Цэвэр агаартай ногоон байгууламжтай орчинд амьдрах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.**

3.4.1. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хувийн тохилог орон сууц барих хотхон хорооллын газрыг олгож, инженерийн шугам сүлжээг байгуулах нөөц боломжийг судалж үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

3.4.2. Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын ажлыг үе шаттайгаар төлөвлөж ажиллана.

3.4.3. Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчний гэрлээр өргөтгөх, тохижуулах, цахилгааны шугамыг өргөтгөх, шинэчлэх ажлыг үе шаттайгаар төлөвлөж зохион байгуулна.

3.4.4. Засаг Даргын Тамгын Газрын байрыг шинээр барих, Хоолон гэр /123/-ын уулзвараас сумын төв дундуур 2.1 км урттай засмал зам тавих ажлыг эдийн засгийн боломжид тулгуурлан судалж шийдвэрлэнэ.

3.4.5. Хөдөөгийн багуудыг багийн төвтэй болгож, төвүүдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, байнгын үйл ажиллагаатай болоход бодлогоор дэмжин ажиллана.

**3.5.Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж төсвийн байгууллагын албан хаагч болон иргэд төсвөө хянах, төсвийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэх зорилтыг хангана.**

3.5.1. Мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа санхүүгийн программыг бүрэн ашиглаж хэвшүүлэх, Төсвийн сахилга батыг сайжруулах, дотоод хяналтыг чангатгах, төсвийн

харилцааг бүх шатанд ил тод, нээлттэй байх зарчмыг сайжруулах зорилгоор шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5.2. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг хангах зорилгоор иргэдийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллана.

## ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

**4.1 Байгаль орчныг хамгаалах, унаган төрх, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, хомсдолоос сэргийлэх, байгаль орчинд нийцтэй бодлого хэрэгжүүлнэ.**

4.1.1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого”-ын баримт бичгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, ой, хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зурвас байгуулан, намар, хаврын улиралд сэргээн сайжруулна.

4.1.2. Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн зохистой ашиглах, хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

4.1.3. “Цэвэр орчин” төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-д тусгагдсаны дагуу аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар бодлогоор дэмжин ажиллана.

4.1.5. Сумын төвийн цөлжилтийг арилгах зорилгоор мод тарих ажлыг иргэд олон нийтийн оролцоотой зохион байгуулж, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлнэ.

ХӨЛӨНБУЙР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.04.19 № 435

танай 2022.04.10-ны № 22/04 -т

ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СЭРГЭЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сэргэлэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сэргэлэн сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сэргэлэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Сэргэлэн сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Сэргэлэн сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.
Хувийг: */Аймгийн/* Сонгуулийн хороонд

Хавсралт 3. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020263

## СЭРГЭЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сэргэлэн сумын Монгол Ардын Намын хорооноос 2022 оны Орон нутгийн нөхөн сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрийг "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их хурлаас баталсан "Алсын хараа 2050", Дорнод аймгийн Монгол Ардын Намаас Орон нутгийн хурлын сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөр, Сэргэлэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад ард иргэдээс гарсан санал, холбогдох байгууллагуудын зөвлөмжийг үндэслэн боловсруулав.

Сэргэлэн сумын Монгол Ардын Намын хорооноос 2022 оны Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох **УРИА: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЕ**

Хэрэгжих хугацаа: 2022-2024 он

### НЭГ: ТӨР - ИРГЭНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРГӨЖНӨ.

1.1. Нутгийн боловсон хүчнийг дэмжиж ажиллана.
1.2. Төрийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглана.
1.3. Төрийн бүх байгууллагуудад ажиллагсдын ажиллах таатай нөхцөлөөр хангахын зэрэгцээ ар гэртээ зарцуулах цаг хугацааг нэмэгдүүлэх зорилгоор бүтээмжид суурилсан урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.
1.4. Баг хөгжлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
1.5. Багийн иргэдийн нийтийн хурлыг чадваржуулах, бэхжүүлэхэд анхаарч ажиллана.
1.6. Шинэ тутам гарч буй цахим гэмт хэрэгт өртөхөөс ард иргэдээ урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллана.
1.7. Малчдын бүлгүүдээр дамжуулан төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

## ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ.

2.1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сумын Эрүүл мэндийн төв болон иргэдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

2.2. Нөхөн сэргээх, физик эмчилгээний тоног төхөөрөмжийг бүрэн дүүрэн ашиглана.

2.3. Хүүхэд багачуудын сурч боловсрох орчныг “Хүүхдэд илүү сайн ээлтэй орчин” болгохын төлөө ажиллана.

2.4. Хүүхэд багачуудын бие даан ажиллах чадварыг нэмэгдүүлэхийн тулд оролцогч бүрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар гэр цэцэрлэг, хөдөлмөр зуслан, төлчин багачууд, мэргэжил бүхэн сайхан гэх мэт зорилтот ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.

2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сурч боловсроход таатай орчин бүрдүүлнэ.

2.6. Сургалтын үйл ажиллагаанд техник технологийн давуу талыг ашиглах, сургалтын хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулна..

2.7. Иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийн үйлчилгээг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.8. Соёл урлагийн үйл ажиллагааг соёлын төвийн хэмжээнд ойлгодог ойлголтыг халж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.9. Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

2.10. Орон нутгийг судлах танхимын үзмэрийн баяжилтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ биет болон биет бус соёлын өвийг нээн илрүүлэх, бүртгэх, хамгаалах, олон нийтэд сурталчлах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

2.11. Бүх нийтийн биеийн тамирыг бүхий л талаар дэмжиж ажиллана.

2.12. “Ахмадаа ачлах” хөтөлбөр, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”, ”Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр” болон хүний хөгжлийг хангахад чиглэсэн бусад төсөл хөтөлбөрүүдийг сум орон нутгийн төвшинд хэрэгжүүлэх сумын дэд хөтөлбөрүүдтэй болгоно.

2.13. Төрийн болон нийтийн эзэмшлийн өмч хөрөнгөнд ариг гамтай хандах, хамгаалахад нь төрийн албан хаагч төдийгүй иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, сэтгэхүйн болон соёлын дадал хэвшлийг бий болгохын төлөө бүх шатанд, сургалтын орчинд, олон нийтийн арга хэмжээнд анхаарч ажиллана.

2.14. “Гэр бүлийн хөгжлийн дэд хөтөлбөр” боловсруулж ажиллана.

2.15. Мэдээллийн технологи, харилцаа холбооны үйлчилгээг өрх бүрд саадгүй хүргэх талаар анхаарч ажиллана.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022 04 19 № 436

танай 2022.4.13 -ны № 04/4 -т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Ардчилсан нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Хөлөнбуйр сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Хөлөнбуйр сумын Ардчилсан нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Хөлөнбуйр сумын Ардчилсан нам"-ын мөрийн хөтөлбөр /............ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт . .5. . . хуудастай.

ДАРГА ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020268

**ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН**
**АРДЧИЛСАН НАМЫН 2022 ОНЫ ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Тус сумын Ардчилсан намаас эхлүүлсэн ажлаа дуусгаж Иргэн бүрийг орлоготой, Өрх бүр нь өсөлттэй байлгах бодлогыг хэрэгжүүлж, Шинэ үеийн Шинэ Хөлөнбуйр сумын цогцлоон хөгжүүлэхийг зорилтыг дэвшүүлэв.

Мөрийн хөтөлбөрийн уриа: УНАЛТ биш ӨСӨЛТ
УХРАЛТ биш ДЭВШИЛТ

## Нэг: Төрийн бодлогын хүрээнд

### *1.1. Төрийн бодлогын хүрээнд*

1.1.1. Мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн бүхий зөвлөхүүдийн холбоог бүх салбарт байгуулж, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлнэ.
1.1.2. Мэргэшсэн, чадварлаг албан хаагчдыг бэлтгэн нутгийн удирдлагын чадавхыг дээшлүүлнэ
1.1.3. Төрийн байгууллагын ажиллагсдыг ажиллах нөхцөл боломжоор хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод шуурхай болгох, тайлагнадаг зарчмыг хэрэгжүүлнэ
1.1.4. Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн орчны тохижилтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байхаар тохижуулж тэднийг нийгмийн харилцаанд бусадтай адил тэгш оролцох боломжийг хангана.
1.1.5. Сумын Үйлдвэрчний эвлэлийн холбоо болон хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, зөвлөлийг хуулийн дагуу ажиллах нөхцөлөөр хангаж хамтран ажиллана.
1.1.6. Төрийн байгууллагын үйлчилгээний ёс зүйг сайжруулж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх арга зүйг хэвшүүлнэ.

### *1.2. Хуулийн хэрэгжилтийн талаар*

1.2.1. Төрийн хуулийг дээдлэн, хуулийн хүрээнд ажиллах зарчмыг баримтлан, хууль тогтоомжийг иргэдэд бодлого чиглэлтэйгээр сурталчлан таниулна.
1.2.2. Гэмт хэрэг, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулна.
1.2.3. Малын хулгайтай тэмцэж таслан зогсоох үр дүнтэй ажлыг зохион байгуулах
1.2.4. Иргэдийн өргөдөл гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх арга механизмыг боловсронгуй болгох
1.2.5. Иргэдэд мэдээлэл олгох баг өдөрлөг, "Иргэдтэй уулзах өдөрлөг" зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

### *1.3. Гадаад харилцааны талаар*

1.3.1. Хөрш зэргэлдээ орших ОХУ–ын Ага, Онон, БНХАУ–ын ӨМӨЗО–ны Шинэ барга зүүн хошуу Шинэхээн балгасуудтай соёл, спорт, боловсрол, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хүрээнд хамтарч ажиллана.
1.3.2. Улс аймагтаа ажлаараа тэргүүлсэн гадаад, дотоодын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн хөгжлийн тэргүүний ажиллагаатай аймаг, сумын аж ахуйн нэгж, байгууллагын ажлын туршлагыг судалж сумандаа хэрэгжүүлэх бодлого барина.

### 1.4. *Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах талаар*

1.4.1. МУ-ын цэргийн шинэтгэлийн бодлого үйл ажиллагааг орон нутагт зохион хэрэгжүүлж, Цэрэг татлагын ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулна. Иргэдийг цэргийн албыг сайн дурын үндсэн дээр

Гэрээгээр
Биеэр
Дүйцүүлэхээр
Мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах ажлыг зохион хэрэгжүүлнэ.

1.4.2. Гамшгаас хамгаалах багаж тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх, засварлах
1.4.3. Иргэдэд гамшгаас хамгаалах талаар сургалт сурталчилгааг зохион байгуулах /нэмэх/
1.4.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

## Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд

### 2.1. *Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын талаар*

2.1.1. Малчин өрх бүрийг нийгмийн даатгалын нэрийн данстай, Эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар арга хэмжээ авна
2.1.2. Зорилтот түвшин буюу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх халамжийн үйлчилгээг хуулийн дагуу үзүүлнэ.
2.1.3. Сумын нийт иргэдэд хэрэгцээний судалгаа хийж түүнд тулгуурласан сургалт, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.
2.1.4. Залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана

### 2.2. *Хөдөлмөр эрхлэлтийн талаар*

2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
2.2.2. Өрхийн бизнесийг дэмжиж бодлогыг хэрэгжүүлнэ.
2.2.3. Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллагсдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгох ажлыг хуулийн дагуу хэрэгжүүлэхэд тавих хяналтыг сайжруулна.
2.2.4. Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 2.3. *Боловсролын талаар*

2.3.1. Сургуулиудыг интернетэд бүрэн холбож, цахим номын сан, мэдээллийн сантай болгоно.
2.3.2. Багш нарын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадад сургах, туршлага судлах ажлыг бодлогоор дэмжинэ.
2.3.3. Сум орон нутгийн хөгжлийн суурь нь "ХҮНИЙ ХӨГЖИЛ" гэж үзэн иргэддээ амьдрах ухааны болон Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг сайжруулан багшлах боловсон хүчний чадварт анхаарна.

- ЕБС-ийн багшлах боловсон хүчний мэргэжлийн Тэргүүлэх зэрэгтэй багшийн индексийг нэмэгдүүлэх, магистрын зэрэгтэй багшийн индексийг нэмэгдүүлэх
- СӨБ-ийн багшлах боловсон хүчний мэргэжлийн Заах аргач, Тэргүүлэх зэрэгтэй багшийн, магистрын зэрэгтэй багшийн тоог бодитоор нэмэгдүүлэх

2117144065
ХТҮ4037 0030091

2.3.4. Сургуулийн өмнөх насны бүх хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах боломжоог нэмэгдүүлэх замаар хувилбарт сургалт /хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг гэх мэт/-ын үйл ажиллагаа, эцэг эхчүүдийн хамтын хөдөлмөр оролцоог дэмжиж ажиллана.
2.3.5. "Оюутны сургалтын дэмжлэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж суманд шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэнэ
2.3.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг камержуулж, хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлнэ.
2.3.7. МСҮТ, Польтехникийн коллежтэй хамтран мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дадлага ажлын хүрээнд малчин иргэдийн амьдралд хүч нэмэгдүүлэх талаар хамтран ажиллах боломжоог хангаж ажиллана.
2.3.8. МСҮТөв, Польтехник коллежоор олгодог Өмнөх мэдлэгийг хүлээн зөвшөөрөх сургалтын хэлбэрийн хүрээнд "Мэргэжлийн үнэмлэх"–жүүлэх, "Түргэвчилсэн мэргэжил олгох хөтөлбөр" – ийг тус сургуулиудтай хамтран хэрэгжүүлнэ.

### 2.4. Спортын асуудлын талаар

2.4.1. Төрөл бүрийн спорт арга хэмжээг зохион байгуулж хамтран ажиллах, өсвөр үе, хүүхэд залуусыг спортоор хичээллэхэд анхаарна.
2.4.2. Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх спортын дугуйлан, клубүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, бүх нийтийн биеийн тамир, спортыг дэмжин ажиллана.
2.4.3. Нийтийн биеийн тамир, барга сурын харваа болон үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх бодлого баримтална.
2.4.4. Олимпын төрлийн спортын багш, дасгалжуулагчийг бэлтгэх ажлыг зохион байгуулна.
2.4.5. Сумаас төрж гарсан спортын алдартнуудын нэрэмжит спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулна.
2.4.6. Тэмдэглэлт баяр, ёслолыг нийтийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээн хэлбэрээр зохион байгуулж хэвшинэ

### 2.5. Соёлын асуудлын талаар

2.5.1. Соёлын төвийн үйл ажиллагааг сэргээн, нийтэд хүртээмжтэй байдлаар байнгын үйл ажиллагаа зохион байгуулах боломжоор хангах
2.5.2. Орон нутгийн түүхийн болоод аялал жуулчлалын газруудын солбилцлыг тогтоож кадастрын зураг хийнэ.
2.5.3.
2.5.4. Хэл, соёл, угийн бичиг хөтлөх, уламжлалт ёс заншлаа залуу хойч үедээ өвлүүлэх зорилгоор соёлын төв, музей, сургуулийг түшиглэн төрөл бүрийн дугуйлан секц хичээллүүлнэ.
2.5.5. Орон нутгийн судлах музейн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.
2.5.6. Үндэсний өв соёлоо хадгалах, уламжлах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг дэмжинэ

### 2.6. Эрүүл мэндийн талаар

2.6.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах
